Нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад ургамлан нөмрөг ургах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шимт хөрсний шимт бодисын агууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, нөхөн сэргээсэн талбайнууд дээр байгалийн унаган төрхөд хэр ойртож байгааг тодорхойлох хөрс, ургамал, амьтан зэрэг байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийг цогц байдлаар тодорхойлох хяналт шинжилгээ, судалгааны ажлыг хийлгүүлэн, зардлын тухайн жилийн БОХ төлөвлөгөөнд тусган төсөвлөх.

Амьтдыг хамгаалах арга хэмжээ:

- Шувуудад зориулан үүр, оромжийг байгуулах нь биологийн төрөл хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь тэдгээрийг өндөр хүчдэлийн шугам, барилга байгууламж дээр суухаас сэргийлэх.

- Уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын ойролцоо бүс нутгаас амьтан агнахгүй байх, мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас тараах зэрэг арга хэмжээг уурхайн дотоод төлөвлөлтөд оруулах.

Нутгийн иргэд, ажилчдын нийгмийн эрүүл ахуй:

Уурхайн ажиллагсдын ихэнх нь тоосжилт, дуу чимээ ихтэй, ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик бохирдолттой хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллах тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөж болзошгүй юм. Иймд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын хувийн хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаж, аюулгүй ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм, норм стандартыг хатуу мөрдөх шаардлагатай.

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр:

- Уурхайн олборлолтоос үүсэх тоосжилт;
- Машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээ, тэнд гарч болох осол, эвдрэл;
- Машин механизм, тоног төхөөрөмжид гарах гэнэтийн осол, ус, цахилгаан, дулааны болон хүнсний хангамжийн тасалдал, саатал;
- Уурхайн үйл ажиллагаанаас бэлчээрийн талбай хомсдох.

3.1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хариуцах эзэн	Зардал, 2024 он /мян.төг/	Гарах үр дүн	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын орчин						
1	Уурхайн талбайд олборлолтын үйл ажиллагаагаар ялгарах тоосны хэмжээг бууруулахын тулд задгай талбайг усалж, чийгтэй байлгах.	Тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	250.0	Тоосжилтоос сэргийлэх	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, - MNS 3384- 82, Агаар мандал.
2	Уурхайн шимт хөрсний болон гадаад овоолгын талбайг хуурай, салхи ихтэй, агаар мандал тогтворгүй үед усалж байх хэрэгтэй.	Тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	250.0	Тоосжилтоос сэргийлэх	Сорьц авахад тавих үндсэн шаардлага, -MNS4585:2007, “Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага”
3	Уурхайн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслийн утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны янданг тусгай шүүлтүүрээр тоноглохын зэрэгцээ техникийн оношилгоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллах.	Төслийн үйл ажиллагааны явцад	“Өгөөжбаян хангай” ХХК	-	Агаарын бохирдлоос сэргийлэх	-MNS5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” -MNS ISO4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” -MNS6063:2010, “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”
Газрын гадарга, хэвлий						
1	Маршрутын бус замаар тээвэрлэлт хийхгүй байх.		Байгаль орчны мэргэжилтэн	-	Хөрс элэгдэл эвдрэлд орох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх.	

2	Уурхайн үйл ажиллагааны явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх.		Байгаль орчны мэргэжилтэн	-	Хөрс элэгдэл эвдрэлд ороос сэргийлэх	
3	Төслийн талбайн орчимд хог хаягдлыг зайлуулахдаа зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.		Байгаль орчны мэргэжилтэн	-		
Хөрсөн бүрхэвч						
1	Тээврийн хэрэгсэлтийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдгүүдийг сайжруулах, нэмэгдүүлэх	2024 онд	“Өгөөжбаян хангай” ХХК	500.0	Хөрс элэгдэл эвдрэлд орох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх.	- MNS 3298- 91, Шинжилгээнд сорьц авахад тавигдах ерөнхий шаардлагууд - MNS 3310- 91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
2	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Уурхайн олборлолт эхлэхээс өмнө	Уурхайн дарга	Дотоод төлөвлөлт өөр	Нөхөн сэргээлтэнд ашиглах	- MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, -MNS5850:2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” -MNS5914:2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт”
3	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	Байнга	Байгаль орчны мэргэжилтэн	300.0	Хөрс бохирдохоос сэргийлэх	-MNS591:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс
4	Шатах тослох материалыг хадгалах, түгээх цэгийг тохижуулж хяналтыг			300.0		

	сайжруулах					хуулалт, хадгалалт” - MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” -MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
Усан орчин						
1	Туул голын уснаас татаж байгаа насос дээр тоолуур тавьж, усны төлбөрийг хугацаанд төлж байх.	Жил бүр	“Өгөөжбаян хангай” ХХК	-	-	-Усны тухай хууль, - MNS 3534-83, Усны шинжилгээнд зориулж сорьц авах
2	Далангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхлэгээ хийх, усан санг үерээс байнга хамгаалж байх	Жил бүр	“Өгөөжбаян хангай” ХХК	Дотоод төлөвлөлт өөр	Гүний ус бохирдохоос сэргийлэх	- MNS 4047- 88, Гадаргын усны чанарыг хянах журам -MNS4047:1988, “Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам” -MNS4586:1998, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” -MNS6148:2010, “Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” -MNS0900:2010, “ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” -MNS4943:2011, “Усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага”
3	Зуны улиралд аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автаж болзошгүй тул үерийн уснаас хамгаалах, усыг хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллгааны явцад	“Өгөөжбаян хангай” ХХК	Дотоод төлөвлөлт өөр	Үер усны аюулаас сэргийлэх	
4	Ундны ус болон тунаах нуурын уснаас дээж авч лабораториор шинжлүүлэх	Жилд 2 удаа	Байгаль орчны мэргэжилтэн	ОХШХ-нд зардал нь орсон.	Ундны усанд хяналт тавих	
5	Талбайн гадна болон дотор талд үерийн уснаас хамгаалах зорилгоор суваг, шуудуу татаж сэргийлэх арга хэмжээ авах.	Жил бүр	“Өгөөжбаян хангай” ХХК	-	-	
Нийт дүн						1600.0

3.2.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цоохор морьт” алтны шороон ордыг ашиглах явцад нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтонд өртсөн талбайд жил бүр хийх шаардлагатай. Нөхөн сэргээлтийн ажилд тусгай зардал төлөвлөн ажиллах бөгөөд уурхайн ашиглагдсан орон зайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Шимт хөрсний овоолгыг хийхдээ “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” /MNS5916:2008/ стандартыг мөрдөн ажилласан.

“Цоохор морьт” алтны шороон ордын уурхайн орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцох зорилготойгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ашигт малтмалын болон байгаль орчны хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэс нь юм.

Дараах хууль актыг баримтлан хэрэгжүүлэх шаардлага тавигдана:

- MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага

Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар /БО-ны болон ХААҮ-ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт /

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ажлын хэмжээ, га	Хугацаа	Жилийн төсөв, 2024 он /мян.төг/	Хариуцах эзэн
1	Техникийн нөхөн сэргээлт	13	2024 онд	12000.0	“Өгөөжбаян хангай” ХХК, Мэргэжлийн байгууллага
2	Биологийн нөхөн сэргээлт	7			
Нийт				12000.0	

3.3.ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Өгөөж баян хангай ХХК нь 2024 дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Цоохор морьтын уурхай дээрээ нөхөн сэргээлтийн ажлын сургалт зохион байгуулна.

№	Арга хэмжээ	Зардал /мян.төг/
1	Орон нутгаас өгсөн 1 га газар нөхөн сэргээлт хийнэ	Дотоод төлөвлөлтөөр
2	Мод тарих	Дотоод төлөвлөлтөөр

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай сумын шивэрт голын орчим 1000 ширхэг (48 15 25.7 103 52 22.9, 48 15 26.4 103 52 23.9, 48 15 27.6 103 52 31.00, 48 15 20.00, 103 52 33.2) мод тарьна.

3.4.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

3.5.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

3.6.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өгөөжбаян хангай” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

“Цоохор морьт” алтны шороон ордын үйл ажиллагааны явцад ямар нэгэн химийн бодис, тэсрэх материал ашигладаггүй учир энэ төрлийн эрсдэл үүсэхгүй. Харин уурхай нь жилдээ 627.1 мян.л түлш, 2.54 тн тос тосолгооны материал хэрэглэдэг.

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, 2024 он /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	700.0	Төслийн үйл ажиллагааны явцад
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулах	-	Жил бүр уурхай эхлэх үед
2	Хүчтэй салхи шуурганы улмаас тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тоосжилтоос үүсэх бусад нөлөөлөл	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	-	Төслийн хугацаанд
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал,	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед уурхайн ажлыг түр	-	Төслийн хугацаанд

	цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	зогсоох		
4	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	800.0	Жилд 1 удаа
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах,	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр
		Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	500.0	
Нийт			2000.0	

3.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам болон үйлдвэрлэлийн хэрэгцээтэй газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь хэтэрхий удаан байдаг учраас байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй байдаг.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдал нь ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэглээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар гэх мэтээс). Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах менежментийн төлөвлөгөөний талаар энэхүү сэдэвт тусгасан болно. Хог хаягддын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн байдаг.

Хатуу хог хаягдал: тус төслийн үйл ажиллагааны хүрээнд ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар сав, шил, лааз, цаас, сав, баглаа боодол, асгарсан шатахуун, шатах тослох материалыг шингээж авсан цаас, алчуур, хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс, техник тоног төхөөрөмжийн хаягдал сэлбэг хэрэгсэл (хаягдал төмөр, утас г.м) зэрэг зүйлс хатуу хог хаягдалд хамаарна.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх хог хаягдлыг тусгай зориулалтын саванд ангилан ялгаж (дахин ашиглах боломжтой эсхээр нь), хатуу хог хаягдалд зориулан барьсан хашаа, хайс хамгаалалттай цэг эсвэл байранд (мал, амьтан орхооргүй, хөрс, усанд шууд шингэх боломжгүй хатуу бетонон хучилтай байх) хадгалах шаардлагатай

бөгөөд Заамар сумын засаг даргын тамгын газаргай байгуулсан гэрээний дагуу Төвлөрсөн хогын цэгт зайлуулж булшлах шаардлагатай болно. Харин дахин ашиглах боломжтой хуванцар сав, шил, лааз, цаас болон хаягдал төмрийг ялган цуглуулж, хоёр дахь түүхий эд боловсруулах үйлдвэрт тушаах нь зүйтэй. Хатуу хог хаягдлыг эмх замбараагүй хаях, буруу хадгалж, зайлуулсны улмаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг бохирдуулагч бодис тархаж, улмаар ажилчид болон төслийн талбай орчмын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүйг онцгойлон анхаарах шаардлагатай.

Шингэн хог хаягдал: тус төслийн үйл ажиллагааны хүрээнд уурхайн хотхоны хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөөнөөс хаягдах бохир ус зэрэг нь нэг төрлийн шингэн хаягдал болно. Тус шингэн хаягдлыг зориулалтын цооногт (хөрс, усанд ахуйн бохир ус алдагдахааргүй доторлож тусгайлан бэлтгэсэн) үнэр дарагч, саармагжуулах бодис хийж түр хадгалаад, Бүрэгхангай сумын засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу зориулалтын машинаар тээвэрлэж зайлуулна.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Зардал, 2024 он /мян.төг/
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгийг Бүрэгхангай сумын засаг даргаар тогтоолгосны дагуу төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх	Уурхайн удирдлага	700.0
2	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын дагуу энгийн хог хаягдлыг ангилан ялгах.	“Өгөөжбаян хангай” ХХК	700.0
3	Ахуйн бохир ариутгаж халдваргүйжүүлэх “тамир эм” бэлдмэлийг хэрэглэх	“Өгөөжбаян хангай” ХХК	200.0
4	Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	“Өгөөжбаян хангай” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
5	Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх	“Өгөөжбаян хангай” ХХК	-
6	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх	“Өгөөжбаян хангай” ХХК	-
7	Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах	“Өгөөжбаян хангай” ХХК	-
8	Орчны эрүүл ахуй хангасан эко 00-той болох	“Өгөөжбаян хангай” ХХК	2000.0
Нийт дүн			3600.0

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх хог хаягдлыг тусгай зориулалтын саванд ангилан ялгаж (дахин ашиглах боломжтой эсхээр нь), хатуу хог хаягдалд зориулан барьсан хашаа, хайс хамгаалалттай цэг эсвэл байранд (мал, амьтан орхооргүй, хөрс, усанд шууд шингэх боломжгүй хатуу бетонон хучилттай байх) хадгалах шаардлагатай бөгөөд Бүрэгхангай сумын засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу Төвлөрсөн хогын цэгт зайлуулж булшлах шаардлагатай болно. Харин дахин ашиглах боломжтой хувинцар сав, шил, лааз, цаас болон хаягдал төмрийг ялган цуглуулж, хоёр дахь түүхий эд боловсруулах үйлдвэрт тушаах нь зүйтэй. Хатуу хог хаягдлыг эмх замбараагүй хаях, буруу хадгалж, зайлуулсны улмаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг бохирдуулагч бодис тархаж, улмаар ажилчид болон төслийн талбай орчмын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүйг онцгойлон анхаарах шаардлагатай.

3.8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цоохор морьт” алтны шороон ордын үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудалд зөвхөн байгаль орчны мэргэжилтэн анхаарал хандуулах биш Захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл / газар хөдлөлт, үер, салхи, шуурга / болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана,
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах,

- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, 2024 он /мян.төг /
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Тогтмол	Уурхайн дарга	Дотоод төлөвлөлтөөр
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Жилд 1 удаа	Байгаль орчны мэргэжилтэн	500.0
3	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах	Жил бүр	“Өгөөжбаян хангай” ХХК	500.0
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Төслийн үйл ажиллагааны явцад	“Өгөөжбаян хангай” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
5	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	“Өгөөжбаян хангай” ХХК	Ашиглалтын зардалд тооцсон
6	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулах	Жил бүр	“Өгөөжбаян хангай” ХХК	Осол эрсдэлийн төлөвлөгөөнд орсон.
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Тогтмол	Уурхайн удирдлага	Удирдлагын зардалд тооцсон
8	Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	“Өгөөжбаян хангай” ХХК	Мэргэжлийн байгууллагатай тохиролцосноор
9	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Төслийн хугацаанд	“Өгөөжбаян хангай” ХХК	Тохиролцох
Нийт дүн				1000.0

3.9.ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ

"Өгөөжбаян хангай" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 11. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төгрөг)	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Булган аймаг, Бүрэг хангай сум, Дэрси багын ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМБТБТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	Булган аймаг, Бүрэгхангай сум, Дэрст багын ИНХ	Булган аймгийн Бүрэг хангай сум
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны засаг дарга, байгаль орчны ТББ	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард		Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгын байцаагч бүх шатны засаг дарга	Засаг даргын тамгын газар
3	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангын эх хувь албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар		БОАЖЯ-ны ХБДБНУГ-ын ажилтан	БОАЖЯ-нд

3.10.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Цоохор морьт” алтны шороон ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“Өгөөжбаян хангай” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналтын хугацаа, давтамж	Зардал, 2024 он /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
Усан орчин					
1	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Унд ахуйн усыг хангаж буй гүний уснаас	Жилд 2 удаа	150.0*2удаа=300.0	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага -MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж -MNS 13.060.50 Усны чанарын стандарт -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих



Хөрсөн бүрхэвч					
				хяналт	
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох./овоолго болон олборлолт явуулж буй талбайн ойролцоо/	Жилд 2 удаа	300	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Нийт дүн				600.0	

**4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ
НИЙТ ЗАРДАЛ**

“Өгөөжбаян хангай” ХХК-ийн 2024 оны БОМТ-г БОНХЯ-ны Сайдын 2014 оны 1 сарын 06-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2024 онд БОМТ-нд нийт 20800.0 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө /Хүснэгт 13/.

Хүснэгт 13. 2024 оны БОМТ-ний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, 2024 он /мян.төг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1600.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	12000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3600.0
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2000.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1000.0
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	600.0
Нийт дүн		20800.0

ДҮГНЭЛТ

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших “Өгөөжбаян хангай” ХХК-ний “Цоохор морьт-1” алтны шороон ордыг ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 20800.0 мян.төг зарцуулахаар төсөвлөлөө.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

“Өгөөжбаян хангай” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг технологийн дагуу гүйцэтгэсэн нөхцөлд сөрөг нөлөөллүүдийг бууруулах боломжтой юм.